БАТЛАВ: ТЭСИЙН ГОЛ, БУЛНАЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.БЯМБАСҮРЭН

ТУЗ34297 Д.4155947

2026 оны 03 сарын 04-ны өдөр

ТЭСИЙН ГОЛ, БУЛНАЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ОЙН САНД АРЧИЛГАА, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ОГТЛОЛТООР МОД БЭЛТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Үндэслэл: Орон нутгийн иргэдийн ахуйн болон түлшний модны хэрэгцээг хангах хүрээнд тусгай хамгаалалттай газрын ойн сангийн зөвшөөрөгдсөн бүсэд мод бэлтгэх ажлыг зохион байгуулахад энэхүү ажлын даалгаврыг мөрдөнө.

№	Ажлын нэр	Арчилгааны огтлолт, Цэвэрлэгээний огтлолт хийх
1	2	3
2	Захиалагч байгууллага	Тэсийн гол, Булнайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа
3	Ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэх газар	Хөвсгөл аймаг Цэцэрлэг сум
4	Мод бэлтгэлийн ажлыг гүйцэтгэхэд мөрдөх хууль тогтоомж	Ойн тухай хууль, Ойн газрын даргын 2025 оны 02 сарын 19-ны өдрийн А/10 дугаар тушаал, Байгаль орчны тухай хууль, Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05-р сарын 01 ний өдрийн А/134 Улсын тусгай хэрэгцээний газрын ойд ойн аж ахуй, арга хэмжээ явуулах журам
5	Ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэх үе шат хугацаа	Захиалагч гүйцэтгэгчийн хооронд гэрээнд заасан хугацааг үндэслэл болгох
6	Техникийн тодорхойлолт	➢ Сонгогдсон багцын хүрээнд ойн арга хэмжээ хэрэгжүүлэх талбайг аж ахуйн нэгж өөрийн хөрөнгөөр холбогдох журмын дагуу тусгаарлуулж, хил заагийг тогтоолгон баталгаажуулна ➢ стандартад нийцсэн бөөрөнхий модыг бэлтгэн, цагаалж, модны захиалга өгсөн иргэнд дээд агуулахаас тээвэрлэлгүйгээр олгох, бусад модыг зүсмэл материал болгон тухай орон нутгийн хэрэгцээнд нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. ➢ Ойн нөөц ашигласны төлбөрийн хэмжээг ойн ангиар тооцуулж, мод бэлтгэлийн ажил эхлэхээс өмнө ойн нөөцийн төлбөрийг тухайн сумын орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлнэ. ➢ Мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагаа бүрийн үед хариуцсан байгаль хамгаалагч нь холбогдох хяналтын хуудсыг журмын дагуу үнэн зөв бөглөж, бүртгэл хөтөлнө. ➢ Ойн ашиглалт, мод бэлтгэлийн үйл ажиллагаанд эхлэл, төгсгөлийн акт болон бусад баримт бичгийг зааврын дагуу бүрэн бүрдүүлж, тухай бүр баталгаажуулна. Мөн ойн үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөө үүсгэхгүй байх зарчимд нийцүүлэн зохион байгуулж, хэрэгжүүлнэ. ➢ Нөхөн сэргээлт хийх, мод тарих: Мод бэлтгэсэн талбай буюу зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын санал

		болгосон газар нутагт тогтвортой ургалттай моддыг зохих аргачлалаар тарьж 2 жилийн хугацаанд арчилгааг хариуцна. (Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг дагаж мөрдөх, үүний тулд бүс нутагт ургуулсан модыг ойжуулалтад ашиглана) ➢ "Ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлсний дараа төслийн тайланг боловсруулж, уг ажлын үр дүн, байгаль орчинд үзүүлсэн нөлөөлөл, нөхөн сэргээлт, хяналт болон үр дүнгийн талаарх мэдээллийг багтаан, талбайг хүлээлгэн өгснөөс хойш 2 сарын дотор бичгээр буюу файл хэлбэрээр тусгай хамгаалалттай газар нутгийн зохих байгууллагад ирүүлнэ.

Ажлын даалгавар боловсруулсан
Ахлах мэргэжилтэн Э.Доржгочоо